

UCS 1605B:2022

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




Такси үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага



ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Такси үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 24-р тогтоолоор батлав.



ГАРЧИГ

| | |
|---|----|
| 1. Хамрах хүрээ | 4 |
| 2. Норматив эшлэл..... | 4 |
| 3. Нэр томъёоны тодорхойлолт..... | 4 |
| 4. Такси үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага..... | 5 |
| 5. Таксины төрөл | 5 |
| 6. Таксины тоноглол | 5 |
| 6.1. Таних тэмдэг | 6 |
| 6.2. Таксины бүхээг | 7 |
| 6.3. Бусад нэмэгдэл төхөөрөмж, хэрэгсэл..... | 7 |
| 7. Такси үйлчилгээний жолоочид тавигдах шаардлага | 7 |
| Хавсралт 1. Тээврийн хэрэгслийг шалгах хуудас..... | 10 |

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|---|
| Зураг 1. Нийтийн такси таних “цоохор” тэмдэг | 6 |
| Зураг 2. Нийтийн такси гараашийн дугаарын хэлбэр, хэмжээс | 6 |



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Зорчигч тээврийн үйлчилгээнд хамаарах
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10^1 дүгээр зүйлийн $10^1.1$ дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Зорчигч тээврийн үйлчилгээ бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1.UCS1601B:2022 “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.2.UCS1602B:2022 “Такси зогсоолд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.3.UCS1603B:2022 “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.4.UCS1604B:2022 “Хүүхдийн автобусанд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.5.UCS1605B:2022 “Такси үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъябазар)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.



1110100333



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн
дүгээр тогтоолын тавдугаар хавсралт

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

UCS 1605B:2022 “ТАКСИ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг такси үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, таксины жолооч дагаж мөрднө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно. MNS 4598:2011 “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага”.

- MNS 4598:2020 “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага”;
- MNS 5012:2021 “Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага”;
- MNS ISO 3833:2010 “Авто тээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт”.
- MNS 4601:2011 “Авто тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт”;
- MNS 5122: 2013 “Такси үйлчилгээ. Ерөнхий шаардлага”;
- Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм;
- Авто тээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Такси - гэж зорчигч болон тээш, гар тээш тээвэрлэхэд зориулагдсан, төлбөртэй явсан замын урт болон үйлчилгээний үнийг тооцох зориулалтын төхөөрөмжөөр тоноглогдсон, тусгай таних тэмдэг бүхий суудлын автомашин;

Такси үйлчилгээ – гэж таксины зориулалтын зогсоолоос эсхүл дуудлагаар такси үйлчилгээг зорчигчдод үзүүлэх тээвэрлэлт;

Таксины зогсоол - гэж такси болон үйлчлүүлэгч зогсоход зориулж тусгайлан тоноглосон зориулалтын барилга байгууламж, талбай;

Таксины жолооч – Энэхүү хотын стандартын 7 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан, такси үйлчилгээ үзүүлж буй жолооч;

Хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан такси үйлчилгээний программ хангамж - гэж такси үйлчилгээний дуудлага хүлээн авч, нийт явсан замыг байршилаар нь тодорхойлох технологи ашиглан тооцоолж, дэлгэцэд харуулах үйлдлийг гүйцэтгэдэг программ хангамж;

Зорчигч – гэж таксиаар зорчиж байгаа зорчигч;

Таксометр- гэж үйлчлүүлэгчийн явсан зайд, хугацаа, үйлчилгээний төлбөрийг тооцоолж дүнг хэвлэх төхөөрөмж;

Тээвэрлэгч- гэж такси ажил, үйлчилгээ эрхэлж буй этгээд;

Дуудлагын такси үйлчилгээ- гэж урьдчилан захиалга өгсөн такси үйлчилгээ.

4. ТАКСИ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. Такси үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь MNS 4598 : 2011 “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага”, MNS 5122 : 2013 “Таксийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавигдах шаардлага” стандартын шаардлагыг хангаж үйлчилгээ үзүүлнэ.
- 4.2. Зорчгчийг цэвэр, цэмцгэр, тав тухтай, аюулгүй зорчих боломжийг хангасан байна.
- 4.3. Техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлнэ.
- 4.4. Тээврийн хэрэгслийн насжилт 10 жилээс бага байна.
- 4.5. Такси үйлчилгээний ажилтан, жолооч болон зорчигч соёлтой, найрсаг харилцааг эрхэмлэнэ.

5. ТАКСИНЫ ТӨРӨЛ

Энгийн такси



(Жишээ зураг)

Үйлчилгээний стандарт нь энгийн байна.

Өнгө: Шар

Өндөр зэрэглэлийн такси



(Жишээ зураг)

Үйлчилгээний стандарт, тариф нь энгийн таксинаас өндөр байна.

Өнгө: Хар

Том оврын такси



(Жишээ зураг)

Том оврын такси нь 6-аас дээш хүний суудалтай автотээврийн хэрэгслээр такси үйлчилгээ үзүүлнэ. Хүүхдийн суудал болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй зорчих нөхцөлийг хангасан байж болно.

Өнгө: Цагаан, шар, хар

Олон улсын такси



(Жишээ зураг)


Олон улсын такси нь үйлчилгээний стандарт, тариф нь энгийн таксинаас өндөр, жолооч нь гадаад хэлний зохих мэдлэг, чадвартай. “International taxi” гэсэн бичиглэл бүхий гэрлэн хаяг /симфор/-тай байна.

Өнгө: Шар


6. ТАКСИНЫ ТОНОГЛОЛ

6.1. Таних тэмдэг

- 6.1.1. Таксинд “ТАКСИ” гэсэн бичиглэл бүхий гэрлэн хаяг /симфор/, таних тэмдэг, аж ахуйн нэгжийн эмблем, харилцах утасны болон автомашины гараашийн дугаарыг тавьж, таксометрээр болон түүнтэй ижил төхөөрөмжөөр тоноглосон байна.
- 6.1.2. Такси таних тэмдэг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 6.1.2.1. Таних тэмдгийн хэмжээ нь уртын дагуу 600x60мм-ээс, доторх шоонууд нь 30x30мм -ээс багагүй хэмжээтэй хар, цагаан, эсхүл ногоон өнгө алгасан хосолсон байна. (1-р зураг);
 - 6.1.2.2. Такси үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын лого нь таксины урд талын 2 хаалган дээр 350x200мм-ийн хэмжээс бүхий хүрээнд багтсан байна;
 - 6.1.2.3. Такси гараашийн дугаар нь арын салхины шилний 2 талын баганад 140x80мм хэмжээтэй байна (2-р зураг);
 - 6.1.2.4. Гараашийн дугаар болон харилцах утасны дугаарын цифрийн хэмжээ 45x30мм байна (3-р зураг).



Зураг 1. Нийтийн такси таних “цоохор” тэмдэг (Жишээ)



Зураг 2. Нийтийн такси гараашийн дугаарын хэлбэр, хэмжээс (Жишээ)

Тоон үсгийн шрифт

1234567890
(Жишээ)

6.2. Таксины бүхээг

Такси үйлчилгээний тээврийн хэрэгсэл дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 6.2.1. Өнгө үзэмж, битүүмжлэл сайн, гадна орчноос тоос шороо, дуу чимээ, ус нэвтрэхгүй байх, салхины болон хажуугийн, арын шилнүүд, шал, хаалга, капот, тээшний түгжээ бүрэн, эвдрэл гэмтэлгүй байна;
- 6.2.2. Суудал түшлэг нь тавлаг зөөлөн, жолоочийн биеийн жин, өндөрөөс хамааруулж тохируулах боломжтой, жолооч, зорчигчдын бие хөлрөх, чийг татахааргүй эрүүл ахуйн шаардлага хангах материалыа бүрсэн байна;
- 6.2.3. Таксины бүхээгт байгууллагын нэр, жолоочийн өнгөт зураг, овог нэр, автомашины улсын ба гараашийн дугаарыг Аб хэмжээнд бичиж зорчигчид харагдах газар хөдөлгөөнгүйгээр байрлуулна.

6.3. Бусад нэмэгдэл төхөөрөмж, хэрэгсэл

- 6.3.1. Таксины бүхээг нь эрүүл ахуй, ариун цэвэр, галын болон хөдөлгөөний аюулгүйн шаардлагыг бүрэн хангасан, дулаацуулга, агааржуулалт, салхижуулалтын систем, цонх, гал унтраагуур, эмийн сан зэргээр тоноглогдсон байна.
- 6.3.2. Жолоочийн ажиллах, зорчигчдын аятай тухтай, аюулгүй зорчих нөхцөлийг бүрэн хангахын тулд дараах нэмэгдэл хэрэгсэл, төхөөрөмжүүдээр тоноглогдсон байх шаардлагатай. Үүнд:
 - нарны хаалт;
 - жолоочийн иж бүрэн багаж хэрэгсэл;
 - автомашины өргүүр;
 - нөөц дугуй /1 ширхэг/;
 - дугуйн эвүүр / 2ширхэг/;
 - эмийн сан;
 - галын хор - галын хор байрлуулах суурь гаргасан байх ба галын хор нь бүрэн бүтэн, хугацаа нь хэтрээгүй, стандартын шаардлагад нийцсэн байх;
 - ослын зогсоолын тэмдэг;
 - цахилгаан тоноглол - гэрэлтүүлэг дохиоллын хэрэгслүүд нь олон улс болон үндэсний стандартын шаардлагыг хангасан байна;
 - хурд хэмжүүр - баталгаажуулагдсан байх бөгөөд дуут дохио бүрэн ажиллагаатай байна;
 - таксометр, түүнтэй ижил тоног төхөөрөмжтэй байна.

7. ТАКСИ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖОЛООЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Такси үйлчилгээний жолооч нь дараах шаардлагыг хангасан байх. Үүнд:

- 7.1. MNS 5122 : 2013 “Таксийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавигдах шаардлага” стандартын шаардлагыг хангах;
- 7.2. Хөдөлгөөн эхлэхээс өмнө техникийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, найдвартай, түргэн шуурхай, аюулгүй, тав тухтай үйлчилгээ үзүүлнэ;
- 7.3. Хот, суурины байршил, хотын зам, замналыг сайтар мэдэж судалсан байх;

- 7.4. Хотын газрын зураг, томоохон албан газар, зочид буудал болон цагдаа, гал команд, хүн эмнэлгийн түргэн тусламж зэрэг байгууллагуудын хаяг, телефон утасны лавлахтай байх;
- 7.5. Зорчигчийг захиалгын дагуу хамгийн ойр, осолгүй замаар хүргэнэ;
- 7.6. Зорчигчтой мэндлэх, соёлтой найрсаг үйлчилгээ үзүүлэх;
- 7.7. Хөдлөх үедээ болон хүрэх газраа ирсэн үедээ зорчигчид мэдэгдэх;
- 7.8. Ачаатай зорчигчийн ачааг ачих, буулгах;
- 7.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн, нялх хүүхэдтэй эхчүүд, бага насны хүүхэд, өндөр настан зэрэг хүмүүсийг таксинд суулгах, буулгахад жолооч анхаарал тавьж заавал туслах;
- 7.10. Такси бүхээгт тавих радио, хөгжмийн чанга сулыг зорчигчийн хүсэлтэд нийцүүлэх;
- 7.11. Явах чиглэлээ зорчигчтой тохиролцон өөрчилж болно;
- 7.12. Такси замд saatсан тохиолдолд зорчигчийг өөр таксинд суулгаж өгөх;
- 7.13. Хувийн ариун цэвэр, гадаад үзэмждээ анхаарах;
- 7.14. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана;
- 7.15. Жолооч нь хар, хар хөх өнгийн костьюм пиджак, цагаан, цайвар цэнхэр цамц, зангиа, цагаан бээлий өмссөн байх.

| № | Дүрэмт хувцас | Зураг | Өнгө |
|---|---------------|--|----------------|
| 1 | Захтай цамц |  (Жишээ зураг) | Цагаан |
| 2 | Өмд |  (Жишээ зураг) | Хар хөх Хар |
| 3 | Хүрэм |  (Жишээ зураг) | Хар хөх Хар |
| 4 | Бээлий |  (Жишээ зураг) | Цагаан |

7.16. Такси жолоочид дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- 7.16.1. Жолооч нь үйлчилгээний үед тамхи татах, утсаар ярих;
- 7.16.2. Хурд хэтрүүлэх, техникийн тодорхойлолтод зааснаас илүү хүн суулгах;
- 7.16.3. Таксометр баталгаажаагүй лац ломбогүй, эвдэрч гэмтсэн бол үйлчилгээнд гаргахыг хориглоно;
- 7.16.3. Зорчигчоос үйлчилгээний хөлсөөс илүү төлбөр нэхэх, авах;
- 7.16.3. Зорчигчтой зүй бус харьцах.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ШАЛГАХ ХУУДАС

20.. оны ... сар... өдөр.... цаг ... минут

Тээврийн хэрэгслийн загвар, марк....., Улсын дугаар....., Байгууллагын нэр
Жолоочийн овог, нэр.....

| | Шалгах асуулт | Тийм | Үгүй |
|-------------------------------|---|--------------------------|--------------------------|
| Нийтлэг шаардлага | Хурд хэмжүүр, дуут дохио бүрэн ажиллагаатай эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Хийн системийн ажиллагаа хэвийн эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Дугуйн хийн даралт, хээний гүн стандартад заасан хэмжээнээс багагүй | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Шил алчуур, цан үлээгүүр хэвийн ажиллагаатай эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Хамгаалах бүс байгаа эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Гадна дотор талын гэрэлтүүлэг стандартын шаардлага хангасан эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Эмийн сан, гал унтраагуур, ослын зогсолтын тэмдэг байгаа эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Салхины шил цуурсан зөрчилгүй эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Жолоочийн суудал гэмтэлгүй, бүрэн бүтэн эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| Хөдөлгүүр, хүч дамжуулах анги | Хөдөлгүүр, хурдны хайрцаг, ерөнхий дамжуулагаас тос, хөргөх системээс шингэн гоожсон эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Дискэн холбоо /авцуулах/ салахгүй буюу хий эргэхгүй байх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Сэнсний оосрын элэгдэл, тохиргоо, гэмтэлтэй эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Яндан болон дуу намсгуур хэвийн эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| Тоормосны систем | Дөрөөний сул ба бүрэн явалт | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Тоормосны шингэн болон хий дамжуулах хоолой, гуурсын битүүмж хэвийн эсэх болон хийн системийн тундас авсан байдал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Зогсоолын тоормос хэвийн эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| Жолооны механизм | Жолооны хурдний сул явалт | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Жолооны хурдийг эргүүлэх хүч | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Жолооны удирдлагын дамжуулга, татуурга, гар нугасан холбоос, эргэх нударганы сул явалт | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| Явах анги | Нум/хийн нум/ пүршний байдал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Амортизаторын хэвийн байдал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| | Дугуй, булны бэхэлгээний байдал | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| Цахилгаан хэрэгсэл | Аккумуляторын / клем/ шон, болон бусад цахилгаан утасны холболт, бүрээс нь хэвийн эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

| | | | |
|---|--|--------------------------|-------------------------------------|
| Үйлчилгээний талаар | Дотор цэвэрлэгээ хийгдсэн эсэх | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| | Гадна цэвэрлэгээ хийгдсэн эсэх | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| | Суудлын бэхэлгээ, бүрээс хэвийн эсэх | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| | Улсын дугаарын харагдах байдал хэвийн эсэх | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| | Дулаацуулга, агааржуулалтын систем, гэрэлтүүлэг, салхижуулалтын систем бүрэн ажиллагаатай эсэх | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| | Санамж бүрэн бүтэн, шаардлагад нийцэхээр байршуулсан эсэх | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| Жолоочид тавих шаардлага | ХАБЭА-н зааварчилгаа авсан байх | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| | Жолоочийн хувийн бэлтгэл хангагдсан эсэх жолооны үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, замын хуудас, мэргэшсэн жолоочийн үнэмлэх, ажлын хувцас, нэрийн хуудас бүрэн эсэх | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| | Байгалийн шахсан хий болон /CNG/, цахилгаан тэжээлт тээврийн хэрэгслийн жолооч нь тусгайлан ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байна. | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| | Жолоочийн биеийн байдал, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| Цахилгаан болон шахсан /CNG/ хийн тэжээлт тээврийн хэрэгсэл | Шахсан хийн тээврийн хэрэгслийн тэжээлийн системийн битүүмж болон даралтад савны аюулгүй байдал хэвийн эсэх | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |
| | Цахилгаан тээврийн хэрэгслийн техникийн байдлыг шалгаж жолоочид техникийн болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсөн байна. | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> |

ТАЙЛБАР: Шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа бол тийм багананд тэмдэглэгээ хийнэ.
Хангахгүй байгаа бол угүй багананд тэмдэглэгээ хийнэ.

Шугамд гарахын өмнө тээврийн хэрэгсэлд техникийн ерөнхий үзлэг хийж үйлчилгээнд гарах ба шугамаас буухдаа тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг шалгах механикчаар заавал шалгуулна.

Техникийн хяналт хийж зөвшөөрсөн

Шалгах механик......./.....

Жолооч......./.....

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

1. Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн дагуу аюулгүй байдлыг хангаж хөдөлгөөнд оролцох.
2. Жолооч ажилд гарахын өмнө тээврийн хэрэгслийн тоормосны систем, гэрэл дохио, хаалга, толь, дугуйг хийн даралтыг шалгасны дараа үйлчилгээнд гарах.
3. Согтууруулах ундаа хэрэглэсэн, биеийн байдал, эрүүл мэнд муудсан, хэт ядарсан үед тээврийн хэрэгслийг жолоодохгүй байх.
4. Замын хөдөлгөөний дүрмийг чанд биелүүлж урд болон хажууд яваа тээврийн хэрэгслийг мөргөхгүй, шүргэхгүй байх зай барьж явах.
5. Төмөр замын гарам нэвтрэх замын хөдөлгөөний дүрмийг чанд мөрдөх.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Наадамчдын зам 1200, Арцатын ам, 4 дүгээр хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар